



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/03

Амардалай

Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц,
орон тоог батлах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, "Сумын ЗДТГ-ын орон тосны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолын 1, "Санхүүгийн алба байгуулах тухай" Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын 1, Хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоол, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан орон тоонд багтаан ажил, албан тушаалын жагсаалт, албан хаагчдын тодорхойлолт, цалинг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ

4880100015

Сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын
04 ний өдрийн А/03 тоот захирамжийн хавсралт



Нэг: Удирдах албан тушаалтан 3

1. Засаг дарга 1 /Төрийн улс төрийн албан тушаалтан/
2. Засаг даргын орлогч 1 /Төрийн улс төрийн албан тушаалтан/
3. Багийн Засаг дарга 3 /Төрийн улс төрийн албан тушаалтан/

Хоёр: ЗДТГ-ын удирдлага 1

1. ЗДТГ-ын дарга 1 /Төрийн жинхэнэ албан хаагч/

Гурав: Санхүүгийн алба /орон тоо 3/

1. Санхүү албаны дарга 1 /Төрийн жинхэнэ албан хаагч/
2. Төрийн сангийн мэргэжилтэн 1 /Төрийн жинхэнэ албан хаагч/
3. Нягтлан бодогч 2 /Төрийн үйлчилгээний гүйцэтгэх ажилтан/

Дөрөв: Хөдөө аж ахуйн тасаг /орон тоо 2/

1. Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн 1 /Төрийн жинхэнэ албан хаагч/
2. МАА үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1 /Төрийн жинхэнэ албан хаагч/

Тав: Төрийн жинхэнэ албан хаагч

1. Байгаль орчны мэргэжилтэн 1
2. Нийгмийн бодлогын мэргэжилтэн 1

Зургаа: Төрийн үйлчилгээний албан тушаал /Гүйцэтгэх албан тушаалтан/

1. Архив, бичиг хэргийн ажилтан 1
2. Нярав 1
3. Жолооч 1

Долоо: Гэрээт ажилтан /орон тоо 2/

1. Үйлчлэгч
2. Слесерь